

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Ерөнхий боловсролын лаборатори Оюуны ирээдүй цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/42/НА-СТ-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он	Тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 7037-3089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 7037-3089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: Ч.Цэрэннадмид Утас: 9511-2689, 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу




**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

**"ОЮУНЫ ИРЭЭДҮЙ" ЦОГЦОЛБОР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.НАРАНТУЯА ТАНАА**

2022.02.25 № 257
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын лаборатори "ОЮУНЫ ИРЭЭДҮЙ" цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын лаборатори "ОЮУНЫ ИРЭЭДҮЙ" цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгслэлдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Ш.МӨНХБАЯР/



009020216

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	288.1	266.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	13,558.6	13,261.8
	Нийт хөрөнгийн дүн	13,846.6	13,528.2
	Нийт өр төлбөрийн дүн	0.0	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,846.6	13,519.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,846.6	13,528.2
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,989.9	5,127.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	4,998.0	5,411.5
	Үйл ажиллагааны үр дүн	(8.1)	(283.5)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(11.1)	(34.9)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(19.2)	(318.4)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,846.6	13,846.6
	Тайлант оны үр дүн		(318.4)
	Эцсийн үлдэгдэл	13,846.6	13,528.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,528.3	4,781.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,480.5	4,720.7
	Үйл ажиллагааны ЦМГ	47.8	60.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(47.8)	(60.3)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,766.5	4,740.8
	Урсгал зардал	4,766.5	4,740.8
	Хөрөнгийн зардал	0.0	0.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	4,528.9	4,528.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	49.0	49.0

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын лаборатори Оюуны ирээдүй цогцолбор сургууль 2021 онд “Багш, хүүхдийн хөгжил, бүх талын хамтын ажиллагаа, оролцоог дэмжин, сургалтын идэвхтэй аргуудаар цахим болон танхимын хосолсон сургалтыг үр дүнтэй зохион байгуулна.” гэсэн зорилгын хүрээнд 5 зорилтыг дэвшүүлжээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын лаборатори Оюуны ирээдүй цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 148 мэдээллийг бүрэн оруулсан, 1 мэдээллийг хоцроосон байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар илэрсэн 1.6 сая төгрөгийн алдааг залруулав.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	1	1.6	1	1.6						
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	1	1.6	1	1.6						